



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Ээлжит хуралдааны тов зарлах,
хэлэлцүүлэх асуудал батлах тухай

Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор батлагдсан “Жендэрийн үндэсний хорооны дүрэм”-ийн 4.1.2 дахь заалт, 5.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хорооны ээлжит хуралдааныг 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн Баасан гаригийн 10:00-11:00 цагт хуралдуулахаар тогтсугай.

2. Хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

- Хорооны 2020 оны төлөвлөгөө болон тогтоолын хэрэгжилт, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл танилцуулах, хэлэлцэх, батлах;
- “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”-г танилцуулах, хэлэлцэх;
- Бусад асуудал.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хуралдааны бэлтгэлийг хангаж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Т.Энхбаяр/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ДАРГА

У.ХҮРЭЛСҮХ

